

**БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨТҮГ-ЫН
ИЛ ТОД БАЙДЛЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН 2020 ОНЫ ХЭРЭГЖИЛТИЙН ТАЙЛАН**

2020 оны жилийн эцсийн байдлаар

Багануур дүүрэг

№	Шалгуур үзүүлэлт	Хэрэгжилт	Хувь
Нэг. Үйл ажиллагааны ил тод байдал			
1.	Эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл болон тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, зохион байгуулалтын бүтцийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	<p>Байгууллагын цахим хуудсанд дараах мэдээллүүдийг байршуулсан. Үүнд:</p> <p>Хөгжлийн бодлого цэсэнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Паркийн хөгжлийн 2017-2020 оны стратеги төлөвлөгөөг 2017 онд Удирдлагын Академийн профессор, доктор, багш н.Ганбаатарын удирдлагын дор паркийн ажилтнууд боловсруулан, тухайн оны НЗД-ын Экологи, ногоон хөгжлийн асуудал хариуцсан орлогч Ж.Батбаясгалан даргад танилцуулж, өгсөн чиглэлийн дагуу Газрын даргаар батлуулсан. ✓ Уг баримт бичигт паркийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйлсийг тодорхойлж хөгжлийн 8 зорилго, 28 зорилт тусгаж нийт 131 ажилбарыг оруулсан. ✓ Паркийн дунд хугацааны 2021-2025 оны стратеги төлөвлөгөөг 2020 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр баталсан ба 8 зорилгын дагуу 24 зорилтын хүрээнд 115 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн. <p>Ил тод цэсэнд:</p> <ul style="list-style-type: none"> ✓ Байгууллагын батлагдсан стратеги төлөвлөгөөний дагуу тухайн онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан сар бүр хэрэгжилтийг тайлагнан ажилласан. 	100%
2.	Үйлчилгээ, захидал харилцааны асуудал хариуцсан албан хаагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албан тушаал, ажиллах журам, харилцах утас, иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	<ul style="list-style-type: none"> ➤ www.baganuur-itp.mn цахим хуудасны ил тод цэсэнд, мэдээллийн самбарын иргэдтэй уулзах мэдээлэл өгөх хэсэгт Байгууллагын захидал харилцаа, өргөдөл гомдол хариуцсан ажилтны мэдээлэл, ажиллах журам, харилцах утас, удирдлагын иргэдийг хүлээн авч уулзах цагийн хуваарийг байршуулан тухай бүр шинэчлэн ажиллаж байна. ➤ Мөн Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын даргын иргэдтэй хийсэн уулзалтын бүртгэлийг улирал тутам байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. 	100%
3.	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	<p>Дараах мэдээллийг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан. Үүнд:</p> <p>Бидний тухай цэсэнд</p> <ul style="list-style-type: none"> ✓ Паркийн тухай ✓ Паркийн нийгэм, эдийн засгийн ач холбогдол 	100%

		<ul style="list-style-type: none"> ✓ Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын үндсэн чиглэл, зорилго, зорилт, танилцуулга Паркийн нэгж цэсэнд ✓ Нэгжид тавигдах шаардлага, нэгжүүдтэй хамтран ажиллах чиглэл болон давуу талуудын талаарх мэдээлэл 	
4.	Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	<ul style="list-style-type: none"> ✓ Монгол Улсын 29 хууль, ✓ ЗГ-ын 15 тогтоол, ✓ НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2015 оны 122 дугаар тогтоолоор батлагдсан Багануур үйлдвэрлэл, технологийн парк ОНӨТҮГ-ын дүрэм, ✓ Дотоод журам зэргийг цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэн ажилласан. 	100%
5.	Шинээр боловсруулж байгаа бодлогын баримт бичиг болон захиргааны хэм хэмжээний актын шийдвэрийн төслийг цахим хуудсандаа 30-аас доошгүй хоног ойлгомжтой байдлаар байрлуулж, холбогдох төрийн ба төрийн бус байгууллага, мэргэжлийн шинжээч, эрдэмтэн, иргэдийн саналыг авах, үндэслэлтэй гэж үзвэл уг саналыг төсөлд тусгах;	Хамааралгүй заалт	-
6.	Үзүүлж байгаа үйлчилгээний арга, хэлбэрийг боловсронгуй болгох зохион байгуулалтын арга хэмжээ авч хэрэгжүүлэх;	<ul style="list-style-type: none"> ➤ ҮТП-ийн эрх зүйн байдлын тухай хуулинд заасан татварын хөнгөлөлт чөлөөлөлтүүдийг Паркийн нэгжүүдэд үзүүлэх ёстой. ➤ Хуулийн заалтуудыг хэрэгжүүлэх журмуудыг Төрийн захиргааны төв байгууллагууд боловсруулан баталж гаргах ёстой боловч өнөөдрийг хүртэл гаргаагүй байна. ➤ Энэ асуудлаар Паркийн асуудал эрхэлсэн УУХҮЯ-ны сайдад хандаж, санал хүргүүлснээр тухайн хуулийг шинэчлэх шаардлагын дагуу ажлын хэсэг байгуулагдаж ажилласан. ➤ Уг ажлын хэсэгт хамтран ажиллаж Паркийн нэгжүүдийн хөрөнгө оруулалтын тогтвортой байдлыг хангах, хөгжлийн таатай орчинг бүрдүүлэх саналуудыг тусгуулсан. ➤ ҮТП-ийн эрх зүйн байдлын тухай хууль нь УИХ-ын энэ оны хаврын чуулганаар батлагдахаар хүлээгдэж байгаа. 	-
7.	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу төрийн байгууллагын гүйцэтгэх тодорхой чиг үүргийг төрийн бус байгууллага гүйцэтгэж байгаа тохиолдолд тухайн төрийн бус байгууллагын нэр, хаяг, цахим хуудас, эрхэлж байгаа үйл ажиллагааны чиглэлийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;	Хамааралгүй заалт	-

8.	Тухайн байгууллага тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагаа эсхүл бусад үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгодог бол тухайн зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, эрхлэх үйл ажиллагааны чиглэл, зөвшөөрөл олгосон болон дуусгавар болох хугацааг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Хамааралгүй заалт	-
9.	Салбарын хэмжээнд улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, явц, байдлын талаарх мэдээллийг цахим хуудсандаа байрлуулан тухай бүр шинэчлэх;	Тайлант онд манай байгууллагад улсын төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөр байхгүй.	-
Хэсгийн дундаж хувь:			100%
Хоёр. Хүний нөөцийн ил тод байдал			
10.	Сул орон тооны зарыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх, энэ тухай олон нийтийн мэдээллийн хэрэгслээр зарлах;	<ul style="list-style-type: none"> ✓ Сул орон тоо гарахад үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшингээр шалгаруулж нөхөн томилж ажиллуулсан. ✓ Тайлант онд 2 ажилтан ажлаас чөлөөлөгдөж, сул орон тооны зарыг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулж, шинээр 2 ажилтанг ажилд томилсон. ✓ Байгууллагын цахим хуудсны Хүний нөөц цэсэнд шинээр ажилд орсон болон хөдөлмөрийн гэрээ цуцалсан албан хаагчдын мэдээг тухай бүр гарган байршуулсан. 	100%
11.	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	Албан хаагчийн ёс зүйн дүрмийг 2019 онд баталж, байгууллагын цахим хуудасны Хүний нөөц цэсэнд байршуулсан. ЗГ-ын 2018 оны 258 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж байгууллагын сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах төлөвлөгөөний биелэлтийг ил тод цэсний байгууллагын төлөвлөгөө, биелэлт дэд цэсэнд байршуулсан.	100%
12.	Хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж, үнэлэх журмыг цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан тухай бүр шинэчлэх;	<ul style="list-style-type: none"> ✓ Байгууллагын цахим хуудасны Хүний нөөц цэсэнд паркийн хүний нөөцийн стратегийг байршуулсан. ✓ АТТ болон АБТ-ыг стандартын дагуу боловсруулж, шаардлагад нийцсэн ажилтнуудыг томилсон. 	100%
13.	Хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2019 онд баталж, төлөвлөгөөг жил бүр гарган хэрэгжилтийн тайланг байгууллагын цахим хуудсанд байршуулсан.	100%
14.	Албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг үнэлэх үйл ажиллагааг үнэн зөв, шударга болгох чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар цахим хуудсандаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж байх;	Ил тод цэсний байгууллагын дүрэм, журам дэд цэсэнд 2018.06.04-ний өдөр Газрын даргын А/13 дугаар тушаалаар батлагдсан албан хаагчдын ажил дүгнэх, ур чадварын нэмэгдэл олгох журмыг, Хүний нөөц цэсэнд ажлын биелэлтийг улирлаар дүгнэсэн хуудсыг тус тус байршуулан ажилласан.	100%

Хэсгийн дундаж хувь:	100%
Хэрэгжилтийн дундаж хувь:	100%

ТАЙЛАН ХЯНАСАН:
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛТ ТЕХНОЛОГИЙН ПАРК
ОНӨТҮГ-ЫН ДАРГА Ч.ЭЛБЭГСАЙХАН



ТАЙЛАН ГАРГАСАН:
ЗАХИРГААНЫ АЛБАНЫ
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН *Э. Энхзаяа* Э.ЭНХЗАЯА